

Хар домын судрууд

Наранзаяа Л¹., Анхцацрал Л¹., Улаан-Од Х²., Сайжрах Б¹.,
Буянт Бай¹., Болд Ш.³

¹"Өвөр Монголын үндэсний их сургууль, ²"Ач" Анагаах ухааны их ургууль,
³Монголын анагаах ухааны академи

Abstract

Sutras of Black Dhom

Naranzaya L¹., Ankhtsatsral L¹., Ulaan-Od Kh²., Sajjirahu B¹., Baoyintu Bai¹., Bold Sh.³
¹"Inner Mongolia University for Nationalities", ²"Ach" Medical University,
³Mongolian Academy of Medical Sciences
Email: zaya0209@yahoo.com

Introduction

Due to the dhom zasal is Mongolian's root medicine, it contains rich of nomadic historical knowledge regarding traditional medicine. Although during the recent years, studies regarding scripts of dhom zasal have been conducting frequently and collecting and saving several number of dhom scriptures, there is lack of studies regarding their content. Therefore, we decided to conduct the current study to identify causes, conditions and evidences related to historical development of dhom zasal.

Goal

We aimed to integrate and compare more than 20 studies in a range of title "Study regarding Script of traditional Mongolian medicine and its ingredients in Sutra of Black Dhom"

Method

We conducted the study by using manuscripts, primary source methods, checklist method, historical comparative method and analysis synthesis method.

We have used following materials khukh khutsiin uvdis orshvoi, sutras of dhom, dhom related research papers, and books.

We took a permission to conduct the current study from the National University of Inner Mongolia and the study subject and methods were confirmed. Due to the study was conducted by historical source method, in each and every citation we took from scripts, we put the author's name to not infringe any copyright.

Results

Within in the study, we reviewed more than 20 Sutra of Dhom and from all the sutras, the sutra titled "khukh khutsiin uvdis orshvoi" attracted our attention inconsiderably due to the decree of Great Chinggis khan dedicated to Chaghatai khan was included in the script. Furthermore, the script was written in Mongolian script and it was studied not thoroughly as well as contains a wide range of information.

The decree in the sutra of Dhom is the historical, rare record which contains novel information related to traditional Mongolian medicine history. Although the exact issue date of decree is still unknown, while thinking back about the state status when the decree issued, it was assumed that could be issued during the time between 1226-1227 years. During this time, many of Sartuul nationalities, civilizations was highly developed and many therapists were working and Medicine was well developed in that time. Moreover, Chaghatai khan was introduced as a khan for a period of time, due to that he could aware of culture, and achievements of medicine of his country. Due to that the Great Chinggis khan

could have sent a decree to Chaghatai khan to find an effective treatment method. But there was lack information regarding who got which disease and what medicine was needed. Therefore, they assumed that disease have occurred among soldiers who are the most significant part of guarding the state and sent therapeutic Dhoms according to most prevalent disease among soldiers.

Conclusion

We translated whole of sutra titled “Khukh khutsiin uvdish orshvoi” as an example due to the sutra contains wide range of information and was written in Mongolian script. Also, the decree of Great Chinggis khan was included in the sutra. Due to the reasons above, we have chosen the sutra from many others. Furthermore, we made an explanation regarding some of complicated words and dhoms were classified according to their dedicated disorders.

Key words: Dhom remedy, Dhom zasal, Khukh khutsiin uvdish orshvoi, Sutra of Black Dhom

Pp. 74-78, References 21

Оршил

Дом засал бол Монголчуудын язгуур анагаах ухаан болсоны хувьд нүүдэлчдийн өнө удаан түүхтэй ардын эмнэлгийн мэдлэг ухааныг баялаг агуулж байдаг юм. Ойрын жилүүдэд дом заслын сурвалж бичгийн судалгаа эрчимтэй явагдаж олон тооны дом судрыг цуглуулан эмхэтгэж, хураан хадгалж байгаа боловч түүний агуулгыг шинжлэн судалж байгаа нь маш цөөхөн байна, тиймээс бид дом заслын үүссэн шалтгаан, нөхцөл, түүхэн хөгжилтэй холбоотой баримтуудыг судлан тогтоохыг зорьсон билээ.

“Хар домын судрууд дахь монгол эм хийгээд эм найрлагын сурвалж бичгийн судалгаа” хэмээх судалгааны ажилдаа бид Академич Ш.Болд эрдэмтний “Монголын уламжлалт анагаах ухааны түүх”, доктор Б.Пүрэвсүрэн гуайн “Монгол дом” гэсэн бүтээл мөн 20 гаруй тооны домын судруудыг судалсан бөгөөд эдгээр судруудаас хамгийн онцлог бүхий судар болох “Хөх хуцын увдис оршвой” хэмээх судар нь бидний сонирхлыг ихэд татсан юм. Учир нь энэхүү судар нь тод монгол бичгээр бичигдсэн, маш бага судлагдсан, хүрээ өргөн, агууламж их мөн энэхүү домын судар дотор Эзэн Богд Чингис хааны зарлиг багтсан байгаа юм.

Материал, арга зүй

Бид энэхүү судалгаандаа эх бичиг, сурвалж бичиг судлалын арга, магадлан жагсаах арга, түүхэн харьцуулалтын арга, анализ синтезийн аргууд ашигласан бөгөөд судалгааны материалд “Хөх хуцын увдис оршвой” хэмээх судар болон бусад домын судрууд, дом болон дом засалтай холбоотой эрдэмтдийн хийсэн судалгааны ном бүтээлүүдийг ашигласан болно.

Эх бичиг, сурвалж бичгийн судлал

Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилго, зорилтууддаа нийцүүлэн хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн түүхийн судалгааг хийж улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзлээ.

Бидний судалгааны гол хэрэглэгдэхүүн нь монгол бичиг тод монгол бичгээр бичигдсэн 20 гаруй домын судрууд бөгөөд Монгол улс болон ӨМӨЗО-ны аймаг, сумын нутгаас эрэн сурвалжлан олсон юм.

Магадлан жагсаах арга

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь сурвалж бичгийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэх арга юм.

Бид судалгаанд хэрэглэгдэхүүн болох хар домын судрыг энэхүү аргаар төрөлжүүлэн жагсааж улмаар хар домын судруудад байгаа дан болон нийлмэл эмийн найрлагыг түүвэрлэн жагсаалт хийж, цагаан толгойн дэс дарааллаар цахим санд оруулж дараагийн судалгаа явуулах боломжийг бүрдүүлнэ.

Түүхэн харьцуулалтын арга

Уламжлалт анагаах ухааны янз бүрийн үед болсон үйл явдлуудыг төрөлжүүлэн хувааж хооронд нь харьцуулах, эмчилгээний онол арга зүй нэг үе шатнаас нөгөөд хэрхэн уламжлан дамжиж ирснийг илрүүлэхэд энэхүү аргыг хэрэглэв.

Анализ синтезийн арга

Энэхүү арга нь эх сурвалжаас түүний агуулганд шууд хамаарах дүгнэлт гаргахад чиглэсэн

судалгааны арга юм. Аливаа эх бичвэр, сурвалж бичгийн агуулгыг тооны, чанарын гэх мэтээр ангилан судалдаг.

Бид энэхүү аргыг хар домын судрыг түүвэрлэн тоог тогтоох, дан эмийн нэршлийг латинаар дүйцүүлэн, амт чанар чадлыг тогтоох, нийлмэл эмийн тус эрдмийг тодруулахад голлон ашигласан.

Бид одоогийн судалгааг 2019.12.04-нд Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар судалгааны ажлын сэдэв, аргачлалыг батлуулан судалгаа хийх зөвшөөрлөө авсан бөгөөд уг судалгаа нь сурвалж бичгийн судалгаа учир ном, бүтээлийн зохиогчийн нэрийг ишлэн авсан тухай бүртээ дурдан зохиогчийн эрхийн ямар нэг асуудал үүсгэхгүй байхад анхаарсан болно.

Үр дүн

Өдгөө манай оронд Монгол домын төрлийн эх бичиг ховордсон байна. Үүний сацуу монгол домын эх бичгийг төрөл зүйл болгож хар дом, цагаан дом, алаг дом тус бүрт нь ялган судалсан бүтээл гараагүй байна [1].

“Хөх хуцын увдис оршвой” домын номын 38 хуудас нүүрэнд “СОД БОГД ЧИНГИС ХААНД, ЦАГААДАЙ ХААН ЧИНИЙ ТЭНД ЭМ БИЛҮҮ (БАЙВ УУ) НАД ӨГЧ ИЛГЭЭ ХЭМЭЭН ЗАРЛИГ БОЛСОНД ХААН ЭМ ЗААЖ ИЛГЭЭВ” гэсэн гарчигтайгаар эмчилгээний домын 80 зүйл бичсэн байдаг.

Энэ домын сударт байгаа зарлиг бол Монголын анагаах ухааны түүхэнд холбогдолтой шинэ мэдээлэл агуулсан түүхийн ховор дурсгал юм. Зарлигийг эргэцүүлэн судалбаас дундад зууны үеийн Монголын анагаах ухааны хөгжлийн түвшин, эмнэлгийн гадаад харилцаа, талын монголчуудын хүн амын өвчлөлтийн байдал, ялангуяа цэргийн хүрээн дэх өвчлөл, эмчилгээний арга барил, цэрэг армийн тогтолцоонд шинжилгээ хийх боломжтой судлагдахуун байна.

Энэ зарлигийн гарсан хугацаа мэдэгдэхгүй байгааг зарлиг гарах үеийн улсын байдлаас ургуулан бодоход Чингис хаан өөрийн үндэслэн байгуулсан тулгар төрийг бэхжүүлэхэд нөр их ажил шаардагдах, түүнийг гардан гүйцэтгэхэд биеийн эрүүл мэндээ сайжруулах нь тулгамдсан ажил болсныг тооцож үзээд амьдралынхаа сүүлийн жилүүдэд тухайлбал 1226-1227 оны үест зарлигласан болов уу гэж таамаглах үндэстэй юм. Түүхэн энэ үед Сартуулын олон ястан үндэстэн соёл, иргэншил нь хөгжингүй

байсны сацуу олон эмч мэргэжилтэнтэй, анагаах ухаан нэлээд чамбай хөгжсөн, тэгээд Цагаадай тэнд өргөмжлөгдөж суугаад тэр ард түмний соёл, анагаах ухааны ололт амжилтыг мэдсэн байхаар хугацаанд ажиллаад байсан учраас тэндээс эмчилгээний сайн арга ирнэ гэж үзэж Чингис хаан олон бага хаадынхаа дундаас Цагаадайд хандан зарлиг буулгасан байж болох юм.

Цагаадайд, их хаан эцгээсээ ирүүлсэн зарлигийг ёсоор болгоход тулгамдаж хэрэгжүүлэх хугацаа хэрэгтэй байсныг дараах үйл явц харуулж байна. Зарлигийн гол агуулга болох “эм бий буюу над өгч илгээ” гэсэн заалтын гүн агуулгыг мэргэн тайлж олох нь хамгийн зангилаа асуудал байжээ. Тэр зарлиг ёсоор хэн өвчилсөн, ямар өвчин хүрсэн, ямар эм хэрэгтэй байгаа нь мэдэгдээгүй байна. Тиймээс төр улсаа хамгаалах хэрэгт амин сүнс болсон цэргийн хүрээнд өвчин гарч хэмээн ухаарч цэргийн бие бүрэлдэхүүн, түүний аж ахуйн хангалтын хэмжээнд тооцоолон, гарсан байж болох өвчний эмчилгээний домог бүртгэж илгээсэн байна. Үүнийг Цагаадайгаас ирүүлсэн домд хамгийн олон нь мэс заслын эмчилгээний дом байгаагаас бас домын эцэст нууц хэмээн бичсэн баримтаас мэдэж болно.

Цагаадай хаанаас ирүүлсэн домын зүйлд олон талын шинжилгээ наад зах нь нэгээхнийг дурьдахад “шувууны хөл хавдваас үнэгний цөс түрхэх сайн” гэснээс үзэхэд Чингисийн цэргийн холбоонд шувуу ашигладаг байсныг гэрчлэх буй заа. “Алтан товч”-д Хятадын Жуйн иргэнийг Боорч, Мухлай хоёрт адил хувааж өгөхтүн. Авч сайн эрсээр нь шувуу бариулж дагуулж явагтун хэмээн Чингис хаан соёрхсон, бас Гүрвэлжин гоо хатан усны хязгаар явагч хөх болжмор барьж сүүлэнд нь бичиг бичиж “Би энэ усанд үхэх буй. Биеийг минь уруу бүү эр, өөд эр” гэж эцэгтээ илгээв гэсэн тэмдэглэл бий нь түүхийн давхар баталгаа болох юм.

Цагаадай хааны ирүүлсэн домын зүйлийг өвчний нэрээр ангилбал:

- Арьсны өвчин анагаах дом 5
- Шүдний өвчин анагаах дом 2
- Цус тогтоох дом 6
- Чихний өвчин анагаах дом 3
- Нүдний өвчин анагаах дом 5
- Хоол боловсруулах эрхтний өвчин анагаах дом 9
- Шээс, бэлэг эрхтний өвчин анагаах дом 6
- Сэтгэл мэдрэлийн өвчин анагаах дом 4

- Халдварт өвчин анагаах дом 6
- Гэмтэл согогийн өвчин анагаах дом 23
- Мал амьтны өвчин анагаах дом 9

Дээрх domuудын дотор гэмтэл согогийн өвчний дом хамгийн олон 23 байгаа нь Цагаадай цэргийн хүрээнд зориулж илгээсэн дом засал болохыг харуулж байна.

Хэлцэмж

Ойрын жилүүдэд дом заслын сурвалж бичгийн судалгаа эрчимтэй явагдаж олон тооны дом судрыг цуглуулан эмхэтгэж, хураан хадгалж байгаа билээ. Тухайлбал Академич Ш.Болд эрдэмтний “Монголын уламжлалт анагаах ухааны түүх” мөн доктор Б.Пүрэвсүрэн гуайн “Монгол дом” хэмээх бүтээлүүдэд дом болон дом заслын тухай нэлээд өргөн хүрээг хамарч судалсан байсан нь бидний судалгааны ажилд их тулгуур болж өгсөн юм.

Нүүдэлчин ардын эмнэлэг, соёлын ололт нь амьтны шууд, шууд бус нөлөө, мал маллах хөдөлмөрийн орчинд мал нь зориудаар биш ч яахын аргагүй туршилтын амьтны үүрэгтэй байсан нь аяндаа анагаах ухааны танин мэдэхүй хөгжихөд чухал ач холбогдолтой байжээ [2].

Дом хүн үүссэн цагаас эхлээ тавьснаар бөөгийн шашинтай домын үүслийг холбох, бөө нар домыг үүдсэн мэт ойлгох нь дэндүү явцуу, хожмын ойлголт болох юм.

Монгол оронд бөөгийн шашин дэлгэрсэн тухайд Б.Ринчен, С.Бадамхатан, Х.Буянбат, Сүрбадрах, Енсон нар өөрсдийн саналаа илэрхийлсэн билээ. Тэдний үзэж буй нь үндсэндээ бөөгийн шашин хүй нэгдлийн үед тухайлбал, хуучин зэвсгийн үед үүсч бий болсон гэж үзэж байна. Харин шинэ чулуун зэвсгийн үе нь МЭӨ 5000-3000 жилийг хамарна [3].

Эртний хүмүүс малыг гаршуулан амьдрал ахуйдаа хэрэглэх болсон нь нүүдэлчдийн домын ухааныг хөгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үзэхээр байна. Монгол оронд мал аж ахуй үүсч хөгжсөнөөр наад зах нь 5000 жил болсон гэж эрдэмтэн судлаачид тооцож байна (М.Төмөржав 1989, А.Я.Лус, С.Н.Боголовский нар 1959, Воронцов, 1972). Иймд Монголчууд Төв Азид амьдарч байсан нүүдэлчин олон овог, аймгийн нэгэн адил эрт дээр үед адгуусан амьтныг гэршүүлэн бэлчээрийн мал аж ахуйг бий болгон хөгжүүлэх явцад мал сүргээ адгуулан маллах, өсгөж үржүүлэхээс эхлээд эдлэж хэрэглэх, эмнэн анагаах ариун баялаг уламжлалт арга туршлага хуримтлуулсан

байжээ [4].

Зэрлэг амьтныг гаршуулж гэрийн тэжээмэл мал бий болсон тэр цагт, хүн зөвхөн нарны элчинд дулдуйдан амьдарч байсан цагаас ангижирч, мал амьтны биеийн дулааныг эрүүл мэндэд зориулан ашиглах сэтгэлгээ бий болсон байна. Эл заслын тухай 2000 жилийн тэртээх Хятадын эртний анагаах ухааны дурсгал “Хуанди Нейжин” хэмээх нангиад бичигт умартын орны төөнө засал гэж тэмдэглэгдсэн бөгөөд хожим VIII зууны үед Төвөд анагаах ухааны өв болсон “Рашааны зүрхэн найман гишүүт нууц увдисын үндэс” зохиолын “Язгуурын үндэс”-ийн Монголын төөнө (хоржи мэза) гэж монголоос үүсэлтэй төөнөх эмчилгээний арга болохыг бүр тодорхой болгож, дорно дахинаа алдаршуулжээ [5].

Ийнхүү эмчилгээний домд мэргэжлийн салбарууд үүсч өргөжсөн тэр үеэс эмчилгээний дом эмпирик хандлагатай болж, түүхийн урт хугацаанд тэр чанараа хадгалсан байна.

Соёлын хөгжилтийн талаар Монгол үндэстэнгүүдэд ихээхэн дэвшил гарсан. XII зууны үед зарим аймгууд голдуу уйгар үсгийн цагаан толгойгоор монгол үгийг авиачлан бичсэн үсэг бичгийг хэрэглэхийн хамт зарим нь Хятад үсгийг хэрэглэж байжээ. Үүнээс өмнө бичиг үсэг гэж байсангүй. Хубилай цэцэн хан өөрийн зарлигаараа 1269 онд Пагва ламыг залж 42 цагаан толгойн үсэгтэй дөрвөлжин монгол үсгийг зохиолгожээ. Энэ дөрвөлжин монгол үсгийг Юан улсыг мөхтөл хэрэглэж байв. 1307 онд Чойжи-Одсэр уйгар үсгийн цагаан толгойгоор монгол үгийг авиачлан тэмдэглэдэг үсгийг нэлээд сайжруулан засч дүрэмжүүлжээ. Энэ бол өнөөг хүртэл хэрэглэж байгаа монгол үсэг болно.

Энэ үеэс бичигдэж эхэлсэн домын шившлэг, зан үйл, эмчилгээний аргуудыг эмхтгэсэн жижиг номуудыг “Хар домын судар”-ууд хэмээн нэрлэдэг. Д.Баттогтох (1991) өөрийн бүтээлдээ “Өвчнийг анагаах энэ эмчилгээ нь бөөгийн шашин, түүний зан үйлтэй холбоотой бөгөөд өвчний ад зэтгэрийг алив нэг юмтай холбон түүнтэй эсрэгцэлдэх буюу нөхцөлдөх зүйлээр нь домнож, үйлддэг арга юм гэсэн” байдаг. Хар домын судруудын гол агуулга, эмчилгээний арга зүйн зарчмууд нь бусад 3 урсгалаас онцгой өөр, нүүдэлчдийн амьдрал, зан, дадалтай нягт уялдаатай байдаг. Жишээ нь: “Хөх хуцын домнолго” сударт хөх хуцын эвэр, элэг, цөс, зүрх, тархи, яс, өөх, зэргээр 13 өвчнийг анагаах тухай дурьдсан байдаг. Өөр нэгэн сударт:

Сүүний ашгийг өгүүлэхүй, туулайн бие дэх эм, үнэгний бие дэх эм, хөх үхрийн бие дэх эм, хар үхрийн бие дэх эмүүдийг өгүүлжээ. Ер нь аливаа гэм, эмгэгийг мал, адгуусны гаралтай эмээр эмчилбэл эрдэнэ мэт сайн гэжээ [6].

Дүгнэлт

Хар домын судрууд дахь монгол эм хийгээд эм найрлагын сурвалж бичгийн судалгаа хэмээх судалгааны ажлын хүрээнд бид Монголчуудын бие зүйн мэдлэгийг дом заслын судар номын агуулгаас тодруулан, урьд нь сайтар судлагдаагүй 20 гаруй судрыг нэгтгэн судалж, хооронд нь харьцуулан тайлбарлав.

Зарим судруудын доторх агуулга давтагдсан тохиолдол нэлээд олон байлаа. Эдгээр домын судруудын агуулга дотор дом үүссэн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс, домын ангилал, дом засал ба бөө мөргөлийн харилцан холбоо, бурханы шашин хийгээд дом засал, дом заслын аргын үүсэлд мал аж ахуйн үзүүлсэн нөлөө зэрэг өргөн цар хүрээг хамарсан судлагдахуунууд байсан.

Бидэнд олдсон домын судруудаас хүрээ нь өргөн, агуулга багтаамж нь том, тод монгол бичгээр бичигдсэн мөн Чингис хааны зарлиг багтсан зэрэг олон онцлог зүйлүүд байгаа учраас “Хөх хуцын увдис оршвой” судрыг жишээ болгон бүхэлд нь орчуулж зарим хүнд бэрх үгийг нь тайлбарласан мөн домын зүйлийг өвчний нэрээр нь ангилан тогтоосон болно.

Дом заслын талаарх баримт, материалуудыг олж тогтоон, түүний үүсэл, хөгжил, өвөрмөц онцлог, эмчилгээний агуулга, ач холбогдлыг нарийвчлан судалж, нэгтгэн дүгнэснээрээ нэг талаас танин мэдэхүйн болон практикийн, нөгөө талаас өвөг дээдсийнхээ оюуны том соёлыг хойч үедээ үнэн зөв, бодитойгоор тайлбарлан таниулж буй хэрэг хэмээн үзэж байна.

Ном зүй

1. Амindaваа Ж. “Дом эмнэлэг”, Ухаалагчийн өврийн дэвтэр, 1968, х.22
2. Баттогтох Д. “Эмгэг согог бүхнийг эдгээн илааршуулагч эм дом, засал, төөнө, зурхай тарнийн судар оршвой”, УБ, 1991, х.57
3. Болд Ш., Амбага М., бусад. Монгол туургатны анагаах ухааны алдарт эмч, маарамба, мэргэдийн намтар. УБ, “Одсар Систем” ХХК, 1999, х.19
4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь, Анагаахын

шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол, УБ, 2005, х.36

5. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх, УБ, ADMON PRINTING, 2006, х.119
6. Пүрэвсүрэн Б. Монгол дом, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2005, х.8, 49, 50
7. Баттогтох Д. “Хар домын судрууд”, УБ, 1991, х.16
8. Дэмбэрэлдорж Д. Хар дом заслын судрын хэлхээс, Эрдэнэт хот, 1993, х.11
9. Пүрэвсүрэн Б., Мэндсайхан З. Хардом ардын бор арга /I хэвлэл/, УБ, 2003, х.224
10. Пүрэвсүрэн Б., Мэндсайхан З. Хардом ардын бор арга, УБ, 2006, х.21
11. Сүн лин. Эртний монгол эмнэлгийн дом засал ба анагаах арга, ӨМ-ын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2016, х.5, 326
12. Хөх хуцын увдис оршвой (Зохиогч тодорхойгүй, нийт 38 нүүр)
13. Авгаандондов Ш. Монгол хар домын судруудын чуулга, УБ, 1991, х.23
14. Дэвшилт Т. Монголын уламжлалт эм дом заслын шидэт рашаан, ӨМШУТМ-ийн хэвлэлийн хороо, 2016, х.19
15. Жамъян Д. Монгол зурхай хүн судлал, УБ, 1990, х.4
16. Галбаабадраа Л. Уламжлалт анагаах ухааны дом засалд суралцагчдын гарын авлага, УБ, 2009, х.23
17. Пүрэвсүрэн Б. Монгол дом, УБ, Мөнхий үсэг ХХК, 2005, х.8, 49, 50
18. Ринчен Б. Заан Залуудай, УБ, 1966, х.67,68
19. Сайнцогт В. “Монголчуудын дом” (монгол судлалын цуврал бичиг), Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1999, х.62
20. Хайдав Ц. Ардын эмнэлэгт хэрэглэж байсан амьтны гаралтай эм, УБ, 1977 х.29
21. Цэдэвсүрэн М., Батхүү Д. “Ардын эмчилгээний уламжлалт арга засал”, УБ, 1990, х.10

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаахын шинжлэх ухааны доктор,
профессор Д.Цэрэндагва*